



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№14 /228/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.18

Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БҮРЭЛДЭХҮҮНД АГРОЭКОЛОГИЙН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Батлан хамгаалах салбараас зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ЗХЖШ нь "Эрдэнэс Таван толгой" ХК, ХААИС-ийн Агроэкологийн сургууль, "Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбоо"-той хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Дээрх ажлын хүрээнд 2022 онд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хэмжээнд нэгтгэл, ангиудын байршил, боломжид тулгуурлан бүсчилсэн байдлаар 9 газарт мод үржүүлгийн газар байгуулах, нэгтгэл, анги, салбар бүрд ногоон хотхоныг бий болгох, ХААИС-ийн Агроэкологийн сургуультай хамтран Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнтэй агроэкологийн мэдлэг олгох анхан, ахисан шатны болон сургагч багш бэлтгэх 3 шатны сургалтыг зохион байгуулж байна. Агроэкологийн анхан шатны сургалтаар нийт бие бүрэлдэхүүнд модны төрөл, зүйлийг ялгаж таних, мод тарьж ургуулах, арчлах, хамгаалах, ойжуулалт хийх, ойг нөхөн сэргээх, агро-ойжуулалтыг хөгжүүлэх, ногоон байгууламж байгуулах онол, арга зүйн мэдлэг олгох бол ахисан болон сургагч багш бэлтгэх сургалтаар эдгээр ажлыг төлөвлөх, удирдан зохион байгуулах

чадвар, дадлагыг олгох юм.

Агроэкологийн анхан шатны 20 цагийн цахим сургалтыг 2021 оны 12 дугаар сард 10 хоногийн хугацаатай зохион байгуулахад офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид, ажилтан албан хаагчид, тэдний гэр бүлийн төлөөлөл, ахмад дайчид зэрэг 2500 орчим хүн хамрагджээ. Түүнчлэн ахисан шатны 60 цагийн цахим сургалтыг энэ сард 10 хоногийн хугацаатай зохион байгуулж, төрлийн цэргийн командлал нэгтгэл, анги, салбаруудын 250 гаруй алба хаагчийг хамруулаад байна.

Сургагч багш бэлтгэх онолын сургалтыг 2 дугаар сард цахимаар зохион байгуулах бөгөөд 4 дүгээр сард Төв аймаг дахь агропаркуудад дадлагажин цаашид нэгтгэл, анги, салбарын бие бүрэлдэхүүнд ойжуулалт, агро-ойжуулалтын талаар зөвлөгөө өгөх, зааж сургах, түгээн дэлгэрүүлэх, мэдээллээр хангах чадавхыг олгох аж.

Ахисан түвшний болон сургагч багш бэлтгэх сургалтын хэерийн дадлагад оролцох алба хаагчдын томилолтын зардал, багаж хэрэгсэл, ажлын хувцсыг ЗХЖШ-аас нэгдсэн журмаар хангахаар төлөвлөсөн байна. Сургалтад хамрагдсан алба хаагчид нэгтгэл, анги, салбартаа болон амьдарч буй орчиндоо мод тарих, ойжуулалт



хийх, агропарк хөгжүүлэх замаар ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, эмийн ургамал, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах, арчлан хамгаалж сурснаар экологийн эрүүл таатай орчинд амьдрахын зэрэгцээ эрүүл, аюулгүй хүнсээр тогтвортой хангагдахыг зэрэгцээ нэмэлт орлоготой болох боломжтой юм.

Зэвсэгт хүчний алба хаагчдад ойжуулалт, агро-ойжуулалтыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой чадавхыг олгосноор ойн сангийн таримал ойн талбайг нэмэгдүүлэх,

зөв зохистой ашиглах, хамгаалах, хүнс, тэжээлийн нөөцийн эргэлтийг бий болгох, тухайн чиглэлийн ажлыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах бололцоо бүрдэнэ.

Энэ нь Монгол Улсын Байгаль орчны салбарт цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр үнэтэй хувь нэмэр оруулж, жишиг ногоон байгууламж болон агро-ойн аж ахуйн системийг Батлан хамгаалах салбарт хөгжүүлж улмаар хөгжлийн тогтвортой байдлыг хангах үндэс, суурийг бий болгож байгаа нь сургалтын гол үр дүн юм.

## БАГАЧУУД ХЗЦК-ЫНХАНД ТАЛАРХЛЫН ЗАХИДАЛ ИЛГЭЭЖЭЭ



"Дэлхийн зөн монгол" олон улсын байгууллага "Монголчууд монголчуудаа" төслийн "Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөр"-тэй Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал 2021 оноос эхлэн хамтран ажиллаж байгаа билээ. Тус хөтөлбөрөөр дамжуулан командлалын бүрэлдэхүүн нийгмийн зорилтод бүлгийн хүүхэд багачуудад нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дураараа мөнгөн тусламж үзүүлж хэвшээд байгаа юм.

Тэгвэл Монгол Улсын ирээдүй болсон

хүүхдүүдийн сургалт хөгжил, хамгаалалд чиглэсэн бяцхан тусламжийн хариуд "Дэлхийн зөн монгол" олон улсын байгууллага болон тэдгээр сурагчдаас талархлын захидал ирүүлжээ.

Захидалд "Эрхэм хүндэт цэргийн ах, эгч нарт баярлалаа. Та бүхний тусч чанарт талархаж, олон багачуудын ирээдүйд эерэг өөрчлөлт авчрах сайн үйлс тань мөнхөд үргэлжлэх болтугай гэж ерөөе. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай" гэжээ.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,267,969 /69.7%/	2,168,125 /66.6%/	968,478 30,0%

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
7584 +112	188	7280

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 331,362,580
Эдгэрсэн	Нийт: 269,037,707
Нас барсан	Нийт: 5,563,425

## Түүхэнд энэ өдөр

1930 он Бүх улаан цэргийн Зөвлөлийн тушаалаар Ховдын хязгаарын цэргийн Жанжин штабыг татан буулгав.  
1954 он. Барилга инженерийн хороог /Барилгын батальон 3, тусгай рот 3/ байгуулав.  
1973 он. БХЯ-ны сайдын тушаалаар Арын албаны газрыг, МАА-ийн Ар талын удирдах газар болгон өргөтгөв.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ -7	🌧️ -22

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	🌧️ 24

## ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,852.00	2,855.0
EUR 🇪🇺	3,255.0	3,265.0
CNY 🇨🇳	448.00	449.20
RUB 🇷🇺	38.10	39.40
JPY 🇯🇵	24.85	25.00
KRW 🇰🇷	2.39	2.40

## ЗУРХАЙ



2022.01.18 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 16/

**ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ХОНЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.35-17.30

Барилдлага:

Арвидах

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Мунхрахуй

Суудал: Хий

Энэ өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, лус тахиx, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатгахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, цөөрөм байгуулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



Цахим шууданд

# АХМАД ЦАНАЧДЫН УАШТ-НД ХЗЦК, АЦК-ЫН БАГ ТАМИРЧИД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ



Агаарын цэргийн командлалын нэрэмжит Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Цэрэгжлийн спортын өвлийн 2 төрөлт, ЦСЦ-ын өвлийн олон төрөлтийн үргэлжлэл болж Ахмад цаначдын улсын аварга шалгаруулах тэмцээн

өнөөдөр Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид амжилттай явагдаж өндөрлөлөө. Тэмцээнд 8 багийн 64 тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт "Цасан зам" цанын холбоо, дэд байрт Хуурай замын

цэргийн командлалын баг, гутгаар байрт Агаарын цэргийн командлалын баг тамирчид шалгарсан байна. Хуурай замын цэргийн командлалын багт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл, Зэвсэгт хүчний 017, 119, 326 дугаар ангийн ахмад цаначин тамирчид нэгджээ.



# ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТАД ХАМРАГДАВ



## Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Нийслэлийн Налайх дүүргийн Онцгой байдлын газраас "Гал түймрээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ" сэдэвт сургалтыг ангийн бие бүрэлдэхүүнд зохион байгууллаа.

Н и й с л э л и й н Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын

хяналтын ахлах байцаагч, ахмад Б.Өлзийсайхан, Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн газрын сургалт, сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн дэслэгч А.Тунгалаг нарын удирдсан энэхүү сургалт нь гал түймэр ба түүний дэгдэлт, гал унтраагуурын бүтэц, объектод байх гал түймрээс

урьдчилан сэргийлэх багаж зэвсэглэлийн байрлал / план зураг/, галын аюулгүй байдлыг хангах техникийн арга хэмжээ, ой хээрийн бүсэд гал түймэр гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг алба хаагчдын ажил үйлс, ахуй амьдралд хэрэгцээтэй мэдлэг олгосон үр дүнтэй сургалт болж өндөрлөсөн юм.

Дэлсэгч Р.БИЛЭГ

# УРЛАГ СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



## Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Энэ сарын 15-ны өдөр хугацаат цэргийн алба хаагчдад "Хүний суурь хүмүүжил, төлөвшил" сэдвээр подкаст сонсон яриа танилцуулга хийж хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт байлдагч М.Баянмөнх, А.Баатархүү, Л.Батзориг, М.Баярмөнх нар өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж идэвхтэй оролцов.

Энэ үеэр гэр бүлийн нандин харилцаа, хүн хүнээ хайрлах хайрын түүхийг

харуулсан "Гэргий" Монголын уран сайхны киног үзүүлээ. Мөн Цэргийн албаны эсрэг гэмт хэргийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг тодорхой жишээгээр тайлбарлан танилцуулав.

Түүнчлэн 16-ны өдөр Монгол орны аймгуудыг танилцуулах ажлын хүрээнд Баянхонгор аймгийн түүхэн дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газруудын талаар танилцуулга хийж, "Чи чадах уу" хөгжөөнт буухиа тоглоом зохион байгууллаа. Хөгжөөнт буухиа тоглоомд рот тус

бүрээс зургаан цэргийн алба хаагчийн бүрэлдэхүүнтэй баг хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс Инженерийн саад байгуулах ротын баг тэргүүлж, Инженер сапёрын ротын баг удаалав.

Ийнхүү өнгөрөгч амралтын өдрүүдэд соёл хүмүүжлийн ажлыг халдвар хамгааллын дэглэмийг сайтар баримтлан зохион явуулж, хугацаат цэргийн алба хаагчдын амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй зөв боловсон өнгөрүүлээ.

Ахлах дэслэгч Г.ТҮМЭНБАЯР

# АЛБА, САЛБАР СУРТАЛЧЛАХ АЯНЫ ХҮРЭЭНД...



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл Нэгтгэл алба, салбар сурталчлах аяны хүрээнд Авто хуягт, техникийн албанаас байнгын бие бүрэлдэхүүний дунд "Миний автомастер", "Дөрвөн бэрх" зэрэг уралдаан, тэмцээнүүдийг зохион байгуулж явууллаа. "Миний автомастерын тэмцээний нэгдүгээр байрт мотобуудлагын батальон, хоёрдугаар байрт Хими, биологоос хамгаалахын алба, "Дөрвөн бэрх" тэмцээнд нэгдүгээр байрт танкийн батальон, хоёрдугаар байрт ар тал, гуравдугаар байрт артиллерийн дивизионы багууд тус тус шалгарлаа. Түүнчлэн алба, салбар сурталчлах шилжин явах тугийг мотобуудлагын батальонд шилжүүлэн өгөв. Хошууч Д.ДОЛГОРЖАВ

# ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧИД УР ЧАДВАРААРАА ӨРСӨЛДЛӨӨ



## Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Ангийн Зенитийн артиллерийн дивизионы

марш тактик тусгай бэлтгэлийн аварга салаа шалгаруулах тэмцээн амжилттай

зохион байгуулагдлаа. Тэмцээний гарааны өмнөх ажиллагаанд жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолт, галын бэлтгэл, биеийн тамирын бэлтгэл, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэлийн нормативын тэмцээн явагдав. Мөн 10 км-ийн маршийн замыг буудлага, гранат шидэлт, саадын зурвас, тактикийн ажиллагаа, хөнөөлийн голомт, байр зүй, химийн цэгүүдээр зохион байгуулж явуулахад ахмад Э.Тэмүүлэй захирагчтай ЗУ-23-2-ийн 1 дүгээр батареяны 2 дугаар салааны тамирчид тэргүүн байр эзэлсэн юм.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



"Соёмбо" сонин



"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ. \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ. \* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шууданд: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)